



**БАЯНХОНГОР АЙМГИЙН  
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ТЭРГҮҮЛЭГЧДИЙН  
ХУРЛЫН ТОГТООЛ**

2019 оны 10 сарын 24 өдөр

Дугаар 109

Номгон

**“Баянхонгор хайрхан фарм” орон нутгийн 7  
өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газрын  
үйл ажиллагаанд хяналт, шалгалт хийж, дүгнэлт  
гаргах ажлын хэсэг байгуулах тухай**

“Баянхонгор хайрхан фарм” орон нутгийн өмчит аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газар нь аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2017 оны 11 дүгээр сарын 06-ны өдрийн 132 дугаар тогтоолоор байгуулагдаж, 3 орон тоотой үйл ажиллагаагаа явуулж эхэлсэн бөгөөд 2018 онд Санхүүгийн хяналт аудитын дүгнэлтээр 370,0 гаруй сая төгрөгийн санхүүгийн зөрчил илэрсэн.

Дээрх зөрчилтэй холбогдуулан аймгийн Засаг даргын зөвлөл, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн хурлаар хэлэлцэн цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээг тодорхойлох зорилгоор аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит бус ХҮИ хуралдаанаар хэлэлцэн дээрх байгууллагын менежмент, санхүүгийн зөрчил үүссэн нөхцөл, цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээг тодорхойлох, санал дүгнэлт гаргах ажлын хэсэг байгуулж ажиллах ажлыг аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдэд даалгах шаардлагатай гэж үзсэнийг ТЭМДЭГЛЭЭД:

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.3, Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ХҮИ хуралдаанаас өгсөн чиглэлийг тус тус үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1. “Баянхонгор хайрхан фарм” орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газрын менежмент, санхүүгийн зөрчил үүссэн нөхцөл, цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээг тодорхойлох, санал дүгнэлт гаргах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч: Г.Хоролсүрэн-Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын төлөөлөгч

Нарийн бичгийн дарга: Л.Жаргалцэцэг-Аймгийн Санхүүгийн хяналт, дотоод аудитын албаны санхүүгийн улсын байцаагч

1190185



Гишүүд: Ж.Дулмаа-Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын төлөөлөгч  
 Л.Баасанбат-Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын төлөөлөгч  
 Д.Энхжаргал-Аймгийн Засаг даргын Тамгын газрын Нийгмийн бодлогын  
 хэлтсийн даргын үүрэг гүйцэтгэгч

М.Дүгэрмаа-Аймгийн Засаг даргын Тамгын газрын Нийгмийн бодлогын  
 хэлтсийн Эрүүл мэндийн асуудал хариуцсан бодлогын мэргэжилтэн

Ш.Гэрэлсүх-Аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн  
 хэлтсийн мэргэжилтэн

С.Батцэцэг-Аймгийн Эрүүл мэндийн газрын Хяналт шинжилгээ үнэлгээний  
 хэлтсийн дарга

Н.Амараа-"Баянхонгор хайрхан фарм" орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот  
 үйлдвэрийн газрын захирал

Г.Ариунбаяр-Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн  
 ажлын албаны төсөв, санхүү хариуцсан ажилтан

С.Дуламсүрэн-Аймгийн Эрүүл мэндийн газрын эмийн асуудал хариуцсан  
 мэргэжилтэн

Т.Гэрэлчулуун-Аймгийн Эрүүл мэндийн газрын эдийн засагч

О.Жаргалмаа-Аймгийн Нэгдсэн эмнэлгийн эм зүйч

2. "Баянхонгор хайрхан фарм" орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот  
 үйлдвэрийн газрын менежмент, санхүүгийн нөхцөл байдал, цаашид авч хэрэгжүүлэх  
 арга хэмжээний талаарх санал дүгнэлтээ аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын  
 Тэргүүлэгчдийн хуралдаанд 2019 оны 11 дүгээр сард багтаан танилцуулахыг ажлын  
 хэсгийн ахлагч /Г.Хоролсүрэн/-д үүрэг болгосугай.

3. Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн иргэдийн  
 Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн нарийн бичгийн даргын үүрэг гүйцэтгэгч  
 /Г.Эрдэнэбат/-д даалгасугай.

ДАРГА



ЦОТГОНБАЯР